

АЮУЛГҮЙ БАЙДАЛ НЭГДҮГЭЭРТ

ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



- » Хөдөлмөр хамгааллын хувцас, каск, ажлын гутал, хувцас, бээлий, нүдний шилийг бүрэн хэрэглүүлнэ
- » Хөдөлмөрийн багаж хэрэгслийн найдвартай ажиллагааг ажил эхлэхийн өмнө шалгаж, зааварчлага өгнө.
- » Онцгой таагүй нөхцөлтэй объектод тэжээлийн эх үүсвэр нь зөвхөн гадна байршина.
- » Тусгаарлах трансформаторын 2-р ороомгийг газардуулахыг хориглоно.
- » Зөөврийн шатан дээрээс цахилгаан багажаар ажил гүйцэтгэхийг хориглоно.
- » Бороо цастай үед хамгаалалтгүй цахилгаан багажаар ажиллахыг хориглоно.
- » Цахилгааны мэргэжлийн зэрэгтэй хүн цахилгаан багажаар ажил гүйцэтгэнэ.
- » Онцгой аюултай өрөөнд 1-р ангиллын багажаар мэргэжлийн 2-р зэрэгтэй хүн ажиллана. Техник үйлчилгээ, засвар үзлэгийг цахилгааний аюулгүй ажиллагааны 3-аас доошгүй зэрэгтэй хүн гүйцэтгэнэ.
- » Цахилгаан багаж ажиллуулахын өмнө аюулгүй байдлыг шалгаж, өөр байрлалд шилжих, багаж солиход залгуураас салгана.
- » Багажны кабель утасны бүрэн бүтэн байдал алдагдсан бол ажил гүйцэтгэхийг хориглоно

АЮУЛГҮЙ БАЙДАЛ НЭГДҮГЭЭРТ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧЛАГА



УРЬДЧИЛСАН ЗААВАРЧЛАГА

Шинээр ажилд анх орж байгаа ажилтанд өгнө. Зааварчлагыг хүний нөөцийн ажилтан, ахлах ажилтан, инженер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжилтэн өгнө.

ӨДӨР ТУТМЫН ЗААВАРЧЛАГА

Засвар, үйлчилгээ хийх инженер техникийн ажилтнуудад өдөр бүр өгнө. Зааварчлагыг тухайн тасаг, цех болон ээлжийн ахлагч өгнө.

ЭЭЛЖИТ БУС ЗААВАРЧЛАГА

Томилолтоор ажиллаж байгаа, технологийн зөрчилтэй, ажлаас 1 сараас доошгүй хугацаагаар хөндийрсөн, ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн, технологи нэвтэрсэн үед өгнө.

Зааварчлагыг тухайн тасаг нэгжийн ахлах ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжилтэн өгнө.

- ☎ 976 7775 2223
- ✉ office@ubfoodwaste.mn
- 🌐 www.ubfoodwaste.mn
- 📌 "ХАЙРЛА"
- 📍 "Улаанбаатар Хотын Хүнсний Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Төсөл"
- 📷 Khairla_



9202-МОН: УЛААНБААТАР ХОТЫН
ХҮНСНИЙ ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН
БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 10 ДҮРЭМ



1 Та өөрийн болон бусдын аюулгүй байдалд хариуцлага хүлээнэ



2 Бүх ослоос урьдчилан сэргийлэх боломжтой



3 Хөдөлмөрийн аюулгүй байдлын заавар, журмыг бүрэн мөрдөнө



4 Хэрэв та сургалт, заавар аваагүй, мэдэхгүй бол ажиллахыг хориглоно



5 Ажилдаа тохирсон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хэрэглэнэ



6 Ажил эхлэхээс өмнө эрсдэлээ үнэлж, бууруулах арга хэмжээ авна



7 Хэзээ ч сул унжсан хувцас хэрэглэл өмсөж, хэрэглэхгүй



8 Ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны заавартай танилцаж гарын үсэг зурна



9 Ажлын байранд эмх цэгцтэй байдлыг хэвшүүлнэ



10 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасаа заавал бүрэн өмсөж заавар авсаны дараа ажлаа эхлүүлнэ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ /ХАБЭА/

ХАБЭА-н тухай хуулийг Монгол Улсын Их хурлаар 2008 оны 5 дугаар сарын 22-нд баталсан.

✓ Хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулсан.




ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ /ХАБ/

Хөдөлмөрлөх явцад ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байх байдал



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ /ХЭА/

Хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан ажилтны бие махбод, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН

- ✓ Ажлын байр нь эмх цэгцтэй, ажил явуулахад аюул, эрсдэлгүй тав тухтай орчин бүрдүүлсэн байх
- ✓ Гэрэлтүүлгийн хувьд эрүүл ахуйн нормд тохирсон, нэгж ажлын талбайд тусах гэрлийн хэмжээ хангалттай байх
- ✓ Ажлын байрны агаарын хэм тогтмол, хэвийн дулаантай байх
- ✓ Ядаргаа үүсгэхээр чимээ шуугиан, доргионгүй байх, хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байх
- ✓ Хальтиргаа, гулгаа үүсээгүй, анхааруулах санамж, тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байх
- ✓ Химийн бодисын ууршилттай, дэгдэмхий бодис бүхий ажлын байранд татах шүүгээ, агааржуулалтын суваг хоолой хэвийн найдвартай ажилладаг байх
- ✓ Тоног төхөөрөмжийн байршил нь эрүүл ахуйн стандартад нийцсэн, ажилтанд эрсдэл, саад учруулахааргүй байх